ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууняам Утас:329871 Цахим хаяг:Sambuunyamya@audit.gov.mn Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас:51-261628 Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Г.АРИУНБУЯН ТАНАА

2025.03.25 № 07/1198
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Бараа материалын тайланд үндсэн хөрөнгийн шинжтэй 3,878.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн болон дансны ангиллыг буруу тайлагнасан;
2. Харьяалах нэгж, байгууллагуудын өглөг дансны үлдэгдэл өмнөх оноос 2,637.7 сая төгрөгөөр нэмэгдсэн;
3. Хөрөнгө оруулалтын тайланд тусгасан 897.1 сая төгрөгийн тусгай зориулалтын материалын хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийгээгүй;
4. Онцгой байдлын харьяа байгууллагууд гэрэл цахилгааны зардлаас 1.6 сая төгрөгийн, шуудан, холбоо, интернэтийн төлбөрийн зардлаас 0.3 сая төгрөгийн, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 21.0 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 41.3 сая төгрөгийн, мэдээлэл, технологийн зардлаас 465.5 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 120.9 сая төгрөгийн, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 10.1 сая төгрөгийн, нийт 660.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд нь

1525071312

бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "ангилал", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нэмэлт санхүүжилтээр Засгийн газрын нөөц хөрөнгөөс нэмэлт санхүүжилтээр төсвийн захирагчид хуваарилсан 52,082.0 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 6,649.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 5,745.5 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16,258.4 сая төгрөг, нийт 80,735.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлснээс 74,717.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 6,018.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс 5,436.4 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэн Сангийн яамны Төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Монгол Улсын гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, албаны бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт, үйлдвэрийн төв 123 дугаар ангийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор "Малчдад тусалъя" хандивын аянд 52 иргэн, 33 аж ахуйн нэгж, 119 төрийн байгууллага, 32 төрийн бус байгууллага зэргээс нэмэлт санхүүжилтийн дансанд 19.1 сая төгрөг, ХААН банкны дансанд 3,870.2 сая төгрөг, нийт 3,882.5 сая төгрөгийн мөнгөн хандив хүлээн авснаас Монгол Улсын Шадар Сайдын 2024 оны 25, 42, 43, 51, 114, Улсын Онцгой комиссын даргын 2024 оны 4, 5, 8, 11, 12 дугаар тушаалын дагуу өвөлжилт хаваржилт хүндэрсэн аймаг, сумдад дэмжлэг үзүүлэх, хаагдсан зам даваах нээх, зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгахад ажилласан алба хаагчдын томилолт, ариутгал халдваргүйтгэлийн төлбөр болон үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор зөөврийн далан, хүн нэг бүрийн усны хувцас, цув, бээлий зэргийг худалдан авахад нийт 3,657.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудал

Онцгой байдлын байгууллагууд нь Гамшгаас хамгаалах хууль, тогтоомж, түүнтэй холбоотой төрийн бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллажээ.

Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах, живсэн тээврийн хэрэгслийг илрүүлэх, байршлыг тогтоох, татан гаргах ажлыг 2021-2024 онуудад Онцгой байдлын ерөнхий газраас удирдан зохион байгуулж Зэвсэгт хүчний жанжин штаб, Шинжлэх ухаан, техникийн их сургууль, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн эрдэмтэд, зөвлөх инженер, судалгааны баг хамтран Хөвсгөл нуурт живсэн "Сүхбаатар" хөлөг онгоц болон бусад 11 автомашин, техник хэрэгслийг 33.4-171 метрийн гүнээс татан гаргаж, тэдгээрт агуулагдаж байсан 50 орчим тонн шатахуун, тос тосолгооны материал, аюултай хог хаягдлыг аюулгүй болгосон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Я.САМБУУНЯМ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**		**193,580,648.2**	**233,640,285.0**
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	493,590.8	763,901.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	20,659,337.7	17,495,273.8
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	1,816,397.7	3,295,250.8
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	82,005,515.8	79,480,233.6
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	79,530,958.9	90,086,127.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	9,074,847.3	42,519,497.5
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**		**342,754,296.2**	**358,709,575.9**
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	342,754,296.2	358,709,575.9
39200	Биет хөрөнгө		310,704,141.3	325,675,121.1
39300	Биет бус хөрөнгө	13	32,050,154.8	33,034,454.9
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**		**536,334,944.3**	**592,349,860.9**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**		**4,916,136.8**	**7,553,852.2**
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	4,916,136.8	7,553,852.2
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	103,702.8	-
41300	Өглөг	17а, 17б	4,811,934.0	7,553,352.2
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	500.0	500.0
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**		**531,418,807.6**	**584,796,008.7**
51	Засгийн газрын хувь оролцоо		531,418,807.6	584,796,008.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		96,977,413.7	96,977,413.7
51200	Хуримтлагдсан үр дүн		386,343,510.1	439,737,812.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		48,097,883.8	48,080,782.1
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**		**536,334,944.3**	**592,349,860.9**

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**		**260,256,572.9**	**399,626,717.8**
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	59,189,238.8	79,657,659.3
120	Нийтлэг татварын бус орлого		59,189,238.8	75,477,326.2
122	Тусламжийн орлого		-	4,180,333.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		201,067,334.1	319,969,058.5
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**2а, 2б**	**205,495,284.0**	**314,532,996.9**
21	УРСГАЛ ЗАРДАЛ		205,495,284.0	313,335,267.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		187,091,841.5	299,530,738.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		94,508,676.4	140,059,437.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,797,097.6	3,704,096.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		6,863,165.3	7,611,464.8
2104	Хангамж, бараа материалын зардал		7,188,923.6	12,035,207.3
2105	Норматив зардал		9,535,125.9	10,652,184.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,865,750.0	6,285,728.3
2107	Томилолт, зочны зардал		1,105,106.5	1,710,942.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		18,023,979.3	23,178,030.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		41,204,016.9	94,293,646.2

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		18,403,442.4	13,804,528.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	1,197,729.8
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**		**54,761,289.0**	**85,093,720.9**
IV	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН**		**42,496.4**	**1,818,328.8**
V	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**		**17,137,070.6**	**34,557,236.5**
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**		**37,666,714.7**	**52,354,813.2**

2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**213,316,054.4**	**341,575,914.1**
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,194,771.1	12,615,092.8
120	Нийтлэг татварын бус орлого	7,194,771.1	9,397,193.3
122	Тусламжийн орлого	-	3,217,899.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	206,121,283.3	328,960,821.3
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**191,544,815.7**	**293,630,180.9**
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,544,815.7	293,630,180.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	164,948,763.7	274,615,572.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,761,090.0	138,931,350.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,848,445.9	3,667,941.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,758,032.6	7,650,933.1
2104	Хангамж, бараа материалын зардал	5,823,675.2	7,472,180.1
2105	Норматив зардал	6,020,358.7	11,844,368.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,972,617.3	9,239,362.2
2107	Томилолт, зочны зардал	1,096,276.5	1,711,187.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,807,560.9	29,812,409.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,860,706.6	64,285,840.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,596,052.0	19,014,608.6
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**21,771,238.8**	**47,945,733.2**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**22,807,727.3**	**47,675,422.3**
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,807,727.3	47,675,422.3
2200	Дотоод эх үүсвэрээр	22,807,727.3	47,675,422.3
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	**(22,807,727.3)**	**(47,675,422.3)**
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	**(1,036,488.6)**	**270,310.9**
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,530,079.3	493,590.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	493,590.8	763,901.6

2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	**2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**493,148,551.5**	**-**	**493,148,551.5**
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,200,886.3	-	1,200,886.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	494,349,437.9	-	494,349,437.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,767,059.4)	-	(1,767,059.4)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,169,714.4	-	1,169,714.4
9	Тайлант үеийн үр дүн	37,666,714.7	-	37,666,714.7
10	**2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**531,418,807.6**	**-**	**531,418,807.6**
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	531,418,807.6	-	531,418,807.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,039,489.6	-	1,039,489.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	532,458,297.2	-	532,458,297.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(11,746.7)	-	(11,746.7)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(5,354.9)	-	(5,354.9)
19	Тайлант үеийн үр дүн	52,354,813.2	-	52,354,813.2
20	**2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл**	**584,796,008.7**	**-**	**584,796,008.7**

2.5 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**262,634,347,200.0**	**261,571,518,523.0**	**1,062,828,677.0**	**99.6**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**221,444,943,900.0**	**220,490,973,082.9**	**953,970,817.1**	**99.6**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**209,933,318,800.0**	**208,983,090,357.0**	**950,228,443.0**	**99.5**
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,739,385,000.0	137,380,397,555.4	358,987,444.6	99.7
210101	Үндсэн цалин	81,684,180,700.0	81,810,084,304.1	(125,903,604.1)	100.2
210102	Нэмэгдэл	49,925,115,600.0	48,976,167,480.8	948,948,119.2	98.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,075,744,100.0	2,476,711,999.5	(400,967,899.5)	119.3
210104	Урамшуулал	4,054,344,600.0	4,117,433,771.0	(63,089,171.0)	101.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,650,732,100.0	3,532,847,891.8	117,884,208.2	96.8
210201	Тэтгэврийн даатгал	563,904,700.0	574,235,683.6	(10,330,983.6)	101.8
210202	Тэтгэмжийн даатгал	78,760,100.0	67,809,677.7	10,950,422.4	86.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	40,818,100.0	36,044,712.4	4,773,387.6	88.3
210204	Ажилгүйдлийн даатгал	41,862,600.0	30,490,306.3	11,372,293.7	72.8
210205	Эрүүл мэндийн даатгал	2,925,386,600.0	2,824,267,511.8	101,119,088.2	96.5

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,935,336,200.0	7,619,495,711.8	315,840,488.2	96.0
210301	Гэрэл, цахилгаан	1,825,950,900.0	1,622,189,191.7	203,761,708.3	88.8
210302	Түлш, халаалт	5,294,157,100.0	5,193,370,606.8	100,786,493.2	98.1
210303	Цэвэр, бохир ус	390,966,300.0	379,778,130.8	11,188,169.2	97.1
210304	Байрны түрээс	424,261,900.0	424,157,782.5	104,117.5	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,341,334,800.0	5,336,118,198.0	5,216,602.0	99.9
210401	Бичиг хэрэг	187,773,300.0	191,926,262.7	(4,152,962.7)	102.2
210402	Тээвэр, шатахуун	4,390,065,700.0	4,390,055,402.8	10,297.2	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	145,857,700.0	145,548,506.7	309,193.3	99.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	30,505,000.0	30,657,321.8	(152,321.8)	100.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	587,133,100.0	577,930,704.1	9,202,395.9	98.4
2105	Норматив зардал	12,438,249,900.0	12,431,643,874.6	6,606,025.4	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	863,929,200.0	863,689,386.7	239,813.3	100.0
210502	Хоол, хүнс	5,161,632,400.0	5,155,269,002.9	6,363,397.1	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,412,688,300.0	6,412,685,485.0	2,815.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,541,434,900.0	10,454,930,953.4	86,503,946.6	99.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,522,248,300.0	2,519,081,477.0	3,166,823.0	99.9
210602	Тавилга	-	(15,175,000.0)	15,175,000.0	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	191,991,100.0	191,954,900.0	36,200.0	100.0
210604	Урсгал засвар	7,827,195,500.0	7,759,069,576.4	68,125,923.6	99.1
2107	Томилолт, зочны зардал	453,530,500.0	468,623,098.0	(15,092,598.0)	103.3
210702	Дотоод албан томилолт	453,530,500.0	468,623,098.0	(15,092,598.0)	103.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,157,431,700.0	31,081,965,401.1	75,466,298.9	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,722,864,400.0	21,695,287,713.1	27,576,686.9	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,595,700.0	14,499,199.2	96,500.8	99.3
210803	Даатгалын үйлчилгээ	5,949,502,800.0	5,948,692,314.7	810,485.3	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,852,600.0	108,739,975.2	16,112,624.8	87.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,678,300.0	22,506,760.0	2,171,540.0	91.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,041,555,400.0	3,040,995,130.3	560,269.7	100.0
210807	Газрын төлбөр	279,304,700.0	251,244,308.5	28,060,391.5	90.0

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	77,800.0	-	77,800.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	675,883,700.0	677,067,673.0	(1,183,973.0)	100.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,884,700.0	144,551,616.0	(1,666,916.0)	101.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	532,999,000.0	532,516,057.0	482,943.0	99.9
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**11,511,625,100.0**	**11,507,882,725.9**	**3,742,374.1**	**100.0**
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	112,510,000.0	111,651,150.9	858,849.1	99.2
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	112,510,000.0	111,651,150.9	858,849.1	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,399,115,100.0	11,396,231,575.0	2,883,525.0	100.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	46,815,000.0	46,797,900.0	17,100.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.0	4,400,000.0	100,000.0	97.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,838,183,200.0	7,838,183,200.0	0.0	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,804,639,200.0	2,804,499,808.0	139,392.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	704,977,700.0	702,350,667.0	2,627,033.0	99.6
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**41,189,403,300.0**	**41,080,545,440.1**	**108,857,859.9**	**99.7**
220001	Барилга байгууламж	5,109,661,100.0	5,106,674,202.0	2,986,898.0	99.9
222001	Тоног төхөөрөмж	17,200,000,000.0	17,094,666,400.0	105,333,600.0	99.4
223001	Бусад хөрөнгө	8,500,000,000.0	8,500,000,000.0	0.0	100.0
224001	Стратегийн нөөц хөрөнгө	10,379,742,200.0	10,379,204,838.1	537,361.9	100.0
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**262,634,347,200.0**	**261,571,518,523.0**	**1,062,828,677.0**	**99.6**
31	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**254,079,079,400.0**	**252,790,467,709.2**	**1,288,611,690.8**	**99.5**
310001	**Улсын төсвөөс санхүүжих**	**254,079,079,400.0**	**252,790,467,709.2**	**1,288,611,690.8**	**99.5**
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**8,555,267,800.0**	**8,781,050,813.8**	**(225,783,013.8)**	**102.6**
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,555,267,800.0	8,781,050,813.8	(225,783,013.8)	102.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	47	47	-	100.0
610001	Төсвийн байгууллага	47	47	-	100.0

2.6 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**-**	**80,735,934,979.49**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**-**	**77,638,160,290.49**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**-**	**71,298,986,923.50**
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,550,952,441.00
210101	Үндсэн цалин	-	115,397,523.00
210102	Нэмэгдэл	-	558,886,214.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	0.00
210104	Урамшуулал	-	54,085,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	822,583,704.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	135,093,670.88
210201	Тэтгэврийн даатгал	-	107,188,652.88
210202	Тэтгэмжийн даатгал	-	527,098.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	226,040.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	226,040.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	26,925,840.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	33,026,233.37
210301	Гэрэл, цахилгаан	-	20,012,359.52
210302	Түлш, халаалт	-	3,785,407.66
210303	Цэвэр, бохир ус	-	9,228,466.19
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,260,843,767.80
210401	Бичиг хэрэг	-	119,284,249.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,789,695,057.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	10,786,470.80
210404	Ном, хэвлэл	-	25,014,750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	13,882,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	302,181,241.00
2105	Норматив зардал	-	1,733,034,951.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	6,974,700.00
210502	Хоол, хүнс	-	628,239,984.88
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,097,820,267.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,609,155,990.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	375,420,660.00
210602	Тавилга	-	20,585,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	6,710,000.00
210604	Урсгал засвар	-	1,206,440,330.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,242,564,776.40
210701	Гадаад албан томилолт	-	122,644,475.40
210702	Дотоод албан томилолт	-	1,097,765,279.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	22,155,022.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,522,848,767.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,516,550,133.05
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	960,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	3,171,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	359,109.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,808,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	61,211,466,325.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	61,019,776,941.12
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	191,689,384.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**-**	**6,339,173,366.99**
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	320,626,680.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	317,626,680.00

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	6,018,546,686.99
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,018,546,686.99
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**-**	**3,097,774,689.00**
2200	Дотоод эх үүсвэрээр	-	3,097,774,689.00
220001	Барилга байгууламж	-	13,700,200.00
221001	Их засвар	-	1,197,729,769.00
223001	Бусад хөрөнгө	-	16,850,000.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	-	40,948,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	1,828,545,920.00
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**-**	**80,735,934,979.49**
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	80,735,934,979.49
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,649,788,471.44
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	52,081,983,704.70
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,745,757,927.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	16,258,404,876.35
III	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**	**-**	**-**
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төвлөрүүлэн захирагч болон харьяа 47 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 33 байгууллагад дүгнэлт гаргаж, 14 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ.

Аудитад хамрагдсан 33 байгууллагуудын 30 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 3 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 84,641.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 10,383.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 21 албан шаардлагыг хүргүүлж, 74,259.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 42 зөвлөмж өгсөн. Үүнээс төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 4,167.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Илрүүлэлт : Онцгой байдлын ерөнхий газрын харьяа зарим байгууллагууд ажилчдын хоол, хүнсний материал худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй нийт 4,167.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", гэсэн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 2 дугаар тогтоолоор батлагдсан босго үнийг баримтлаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 49,489.7 сая төгрөгийн 67 алдаа[1] илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 38,202.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 55.6 сая төгрөгийн зөрчилд 25 төлбөрийн акт тогтоож, 24,481.8 сая төгрөгийн зөрчилд 49 албан шаардлага хүргүүлж, 13,665.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 62 зөвлөмжийг өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 38,202.5 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 35,976.6 сая төгрөгөөр их тул “**Хязгаарлалттай”** дүгнэлт өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 8,601.9 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 3,455.9 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 1,557.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлагыг хүргүүлж, 3,588.1 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Онцгой байдлын харьяа байгууллагууд гэрэл цахилгааны зардлаас 1.6 сая төгрөгийн, шуудан, холбоо, интернэтийн төлбөрийн зардлаас 0.3 сая төгрөгийн, бага үнэтэй, түргэн

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 21.0 сая төгрөгийн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний хураамжийн зардлаас 41.3 сая төгрөгийн, мэдээлэл, технологийн зардлаас 465.5 сая төгрөгийн, бараа үйлчилгээний бусад зардлаас 120.9 сая төгрөгийн, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 10.1 сая төгрөгийн, нийт 660.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж зарлагын эдийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн зориулалтын болон эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж байх, зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

2. Онцгой байдлын ерөнхий газрын хөрөнгө оруулалтын тайланд тусгасан 897.0 сая төгрөгийн тусгай зориулалтын материалын хөрөнгийн тооллогыг хийгээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/", 72 дугаар зүйлийн 4-т "Тооллогын комисс дараах үүрэгтэй:”, 1/ эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд чанартай гүйцэтгэж байх, зөрчлийг таслан зогсоох талаар албан шаардлага хүргүүлэв.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Борлуулах бараа материалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт 1. Засгийн газрын 2018 оны 364 дүгээр "МН" тогтоолын 3 дугаар хавсралт, 2023 оны 365 дугаар тогтоолын дагуу нөөцөөс борлуулан сэлгэхээр техник, хэрэгсэл, бараа чөлөөлөгдсөний дагуу 185 дугаар ангийн барааг борлуулах явц, тогтоолын хэрэгжилт удаашралтай, тайлант оны эцэст 950.4 сая төгрөгийн борлуулан сэлгэх барааны үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2018 оны 364 дүгээр "МН" тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу үлдэгдэл барааг борлуулаагүй, тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг хангах

2. Өглөгтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт 2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар харьяалах нэгж байгууллагуудын өглөг дансны үлдэгдэл өмнөх оноос 2,637.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

3. Нягтлан бодох бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт 3. Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумд "Аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих" зориулалтаар ашиглах эрхтэй 13,605.31 м2 талбай бүхий тусгай хамгаалалттай газрыг 2023 онд Онцгой байдлын ерөнхий газарт 10 жилийн хугацаатай олгосон боловч биет бус хөрөнгөд бүртгэлгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ашиглах эрхтэй газрыг харьяа байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэх.

4. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 4. Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харьяа 47 байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 266 алдаа зөрчил илэрснээс санхүүгийн тайлантай холбоотой 49,489.6 сая төгрөгийн 67 алдаа, 38,202.5 сая төгрөгийн 136 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 84,641.9 сая төгрөгийн 63 зөрчил илэрсэн нь төсвийн төвлөрүүлэн захирагчаас санхүү, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын үр дүнтэй хэрэгжүүлэн, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, зөрчлийг 20 хувиар багасгах арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 49,489.7 сая төгрөгийн алдаа илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Онцгой байдлын ерөнхий газрын ТТЗ	8	3,455,881.5	-	-	8	3,455,881.5	8	3,455,881.5	-	-	-	-
Онцгой байдлын ерөнхий газар ТШЗ	4	39,546,010.5	-	-	4	39,546,010.5	4	39,546,010.5	-	-	-	-
Уул уурхайн аврах 09 дүгээр анги	1	248,314.9	-	-	1	248,314.9	1	248,314.9	-	-	-	-
112 дугаар анги	1	49,980.0	-	-	1	49,980.0	1	49,980.0	-	-	-	-
Ар талын 115 дугаар анги	2	295,691.9	-	-	2	295,691.9	2	295,691.9	-	-	-	-
Аврагч биеийн тамир, техник-спорт хороо 120 дугаар анги	1	90,628.0	-	-	1	90,628.0	1	90,628.0	-	-	-	-
Онцгой тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв 121 дүгээр анги	1	49,000.0	-	-	1	49,000.0	1	49,000.0	-	-	-	-
Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт үйлдвэрийн төв 123 дугаар анги	3	52,439.8	-	-	3	52,439.8	3	52,439.8	-	-	-	-
185 дугаар анги	5	2,587,833.4	-	-	5	2,587,833.4	5	2,587,833.4	-	-	-	-
Гамшиг судлалын хүрээлэн	1	135,234.2	-	-	1	135,234.2	1	135,234.2	-	-	-	-
Үндэсний аврах бригад	1	63,411.8	-	-	1	63,411.8	1	63,411.8	-	-	-	-
Сонгинохайрхан дүүргийн ОБХ	1	1,862.6	-	-	1	1,862.6	1	1,862.6	-	-	-	-
Сүхбаатар дүүргийн ОБХ	3	90,694.1	1	1,171.8	2	89,522.3	3	90,694.1	-	-	-	-
Хан-Уул дүүргийн ОБХ	1	540,476.1	-	-	1	540,476.1	1	540,476.1	-	-	-	-
Чингэлтэй дүүргийн ОБХ	1	2,088.0	-	-	1	2,088.0	1	2,088.0	-	-	-	-
Багахангай дүүргийн ОБХ	1	7,500.0	-	-	1	7,500.0	1	7,500.0	-	-	-	-
Налайх дүүргийн ОБХ	4	66,845.7	-	-	4	66,845.7	4	66,845.7	-	-	-	-
Багануур дүүргийн ОБХ	4	297,146.4	1	350.4	3	296,796.0	4	297,146.4	-	-	-	-
Баянгол дүүргийн ОБХ	2	10,890.9	-	-	2	10,890.9	2	10,890.9	-	-	-	-
Баянзүрх дүүргийн ОБХ	1	2,747.2	-	-	1	2,747.2	1	2,747.2	-	-	-	-
Архангай аймгийн ОБХ	2	20,356.9	1	2,356.9	1	18,000.0	2	20,356.9	-	-	-	-
Баян-Өлгий аймгийн ОБГ	1	80,692.9	-	-	1	80,692.9	1	80,692.9	-	-	-	-
Булган аймгийн ОБГ	2	16,700.7	2	16,700.7	-	-	2	16,700.7	-	-	-	-

Говь-Алтай аймгийн ОБГ	1	2,748.4	1	2,748.4	-	-	1	2,748.4	-	-	-	-
Дорноговь аймгийн ОБГ	4	1,479,249.5	-	-	4	1,479,249.5	4	1,479,249.5	-	-	-	-
Дорнод аймгийн ОБГ	1	54,182.6	1	54,182.6	-	-	1	54,182.6	-	-	-	-
Дундговь аймгийн ОБГ	1	19,500.0	-	-	1	19,500.0	1	19,500.0	-	-	-	-
Өмнөговь аймгийн ОБГ	2	12,304.9	-	-	2	12,304.9	2	12,304.9	-	-	-	-
Сүхбаатар аймгийн ОБГ	2	25,212.5	-	-	2	25,212.5	2	25,212.5	-	-	-	-
Төв аймгийн ОБГ	2	55,219.0	-	-	2	55,219.0	2	55,219.0	-	-	-	-
Ховд аймгийн ОБГ	2	116,812.9	1	19,700.0	1	97,112.9	2	116,812.9	-	-	-	-
Хөвсгөл аймгийн ОБГ	1	12,000.0	1	12,000.0	-	-	1	12,000.0	-	-	-	-
Дүн	**67**	**49,489,657.3**	**9**	**109,210.8**	**58**	**49,380,446.5**	**67**	**49,489,657.3**	-	-	-	-

4.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 38,202.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 55.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24,481.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 13,665.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Онцгой байдлын ерөнхий газрын ТТЗ	6	5,146,047.5	-	-	2	1,557,930.7	4	3,588,116.8	-	-
Онцгой байдлын ерөнхий газар ТШЗ	15	25,748,106.3	1	7,468.7	7	20,535,388.9	7	5,205,248.7	-	-
Уул уурхайн аврах 09 дүгээр анги	3	466,693.9	-	-	1	193,893.7	2	272,800.2	-	-
Агааараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги	4	3,061,586.7	-	-	-	-	4	3,061,586.7	-	-
112 дугаар анги	3	3,700.0	-	-	1	1,500.0	2	2,200.0	-	-
Жаргалант сэргээн заслын төв 113 дугаар анги	1	1,303.6	1	1,303.6	-	-	-	-	-	-
Ар талын 115 дугаар анги	3	128,145.6	1	1,664.9	-	-	2	126,480.7	-	-
Аврагч биеийн тамир, техник-спорт хороо 120 дугаар анги	3	23,176.7	-	-	1	10,476.7	2	12,700.0	-	-
Онцгой тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв 121 дүгээр анги	1	332.7	1	332.7	-	-	-	-	-	-
Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт үйлдвэрийн төв 123 дугаар анги	2	22,704.3	-	-	-	-	2	22,704.3	-	-

179 дүгээр анги	4	62,730.3	1	2,607.3	1	3,915.0	2	56,208.0	-	-
185 дугаар анги	5	99,722.7	1	3,299.0	1	1,672.0	3	94,751.7	-	-
Гамшиг судлалын хүрээлэн	2	343.2	1	343.2	-	-	1	-	-	-
Үндэсний аврах бригад	3	1,521,397.1	-	-	1	1,432,323.0	2	89,074.1	-	-
Нийслэлийн ОБГ	3	81,157.4	-	-	2	81,157.4	1		-	-
Сонгинохайрхан дүүргийн ОБХ	3	62,722.5	1	2,381.2	2	60,341.3	-	-	-	-
Сүхбаатар дүүргийн ОБХ	3	42,200.5	1	2,075.3	2	40,125.2	-	-	-	-
Хан-Уул дүүргийн ОБХ	4	60,958.5	2	4,317.0	1	42,353.3	1	14,288.2	-	-
Чингэлтэй дүүргийн ОБХ	3	33,229.8	1	1,332.4	1	31,897.4	1	-	-	-
Налайх дүүргийн ОБХ	2	20,455.1	-	-	1	20,455.1	1	-	-	-
Багануур дүүргийн ОБХ	1	366.3	1	366.3	-	-	-	-	-	-
Баянгол дүүргийн ОБХ	3	30,595.7	1	1,718.2	1	22,337.5	1	6,540.0	-	-
Баянзүрх дүүргийн ОБХ	3	31,362.1	1	1,094.3	1	27,517.8	1	2,750.0	-	-
Архангай аймгийн ОБГ	4	6,702.8	1	345.9	3	6,356.9			-	-
Баянхонгор аймгийн ОБГ	2	67,145.1			2	67,145.1			-	-
Баян-Өлгий аймгийн ОБГ	2	12,793.9	-	-	1	1,850.4	1	10,943.5	-	-
Булган аймгийн ОБГ	8	123,490.9	2	2,454.1	2	7,290.0	4	113,746.8	-	-
Говь-Алтай аймгийн ОБГ	2	1,415.6	2	1,415.6	-	-	-	-	-	-
Говьсүмбэр аймгийн ОБГ	2	11,964.0	1	4,800.0	-	-	1	7,164.0	-	-
Дархан-Уул аймгийн ОБГ	2	10,774.0	1	9,152.0	-	-	1	1,622.0	-	-
Дорнод аймгийн ОБГ	3	288,125.9	-	-	1	181,784.5	2	106,341.4	-	-
Дундговь аймгийн ОБГ	1	1,850.4	-	-	1	1,850.4	-	-	-	-
Орхон аймгийн ОБГ	6	49,495.6	1	3,946.6	2	11,363.2	3	34,185.8	-	-
Өвөрхангай аймгийн ОБГ	1	792,560.0	-	-	-	-	1	792,560.0	-	-
Өмнөговь аймгийн ОБГ	4	34,062.0	-	-	3	34,062.0	1		-	-
Сүхбаатар аймгийн ОБГ	2	6,996.6	-	-	-	-	2	6,996.6	-	-
Сэлэнгэ аймгийн ОБГ	5	47,467.0	-	-	4	47,467.0	1		-	-
Төв аймгийн ОБГ	7	25,594.6	1	692.8	2	8,270.0	4	16,631.8	-	-
Ховд аймгийн ОБГ	2	45,535.7	-	-	1	26,035.7	1	19,500.0	-	-
Хөвсгөл аймгийн ОБГ	2	2,500.3	1	2,500.3	-	-	1	-	-	-
Хэнтий аймгийн ОБГ	1	25,000.0	-	-	1	25,000.0	-	-	-	-
Дүн	**136**	**38,202,512.9**	**25**	**55,611.4**	**49**	**24,481,760.2**	**62**	**13,665,141.3**	-	-

4.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудиттай холбоотой нийт 84,641.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 10,383.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлж, 74,259.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Онцгой байдлын ерөнхий газрын ТШЗ	1	17,191,627.5	-	-	-	-	1	17,191,627.5
Уул уурхайн аврах 09 дүгээр анги	1	2,112,000.9	-	-	-	-	1	2,112,000.9
Агааараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги	1	6,618,989.1	-	-	-	-	1	6,618,989.1
112 дугаар анги	1	1,431,755.2	-	-	-	-	1	1,431,755.2
Жаргалант сэргээн заслын төв 113 дугаар анги	1	2,982,495.4	-	-	-	-	1	2,982,495.4
Ар талын 115 дугаар анги	1	8,819,931.5	-	-	-	-	1	8,819,931.5
Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр анги	1	958,525.0	-	-	-	-	1	958,525.0
Аврагч биеийн тамир, техник-спорт хороо 120 дугаар анги	1	686,261.2	-	-	-	-	1	686,261.2
Онцгой тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв 121 дүгээр анги	1	5,025,707.4	-	-	-	-	1	5,025,707.4
Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт үйлдвэрийн төв 123 дугаар анги	1	1,446,457.3	-	-	-	-	1	1,446,457.3
179 дүгээр анги	1	1,109,138.7	-	-	-	-	1	1,109,138.7
185 дугаар анги	1	2,116,636.2	-	-	-	-	1	2,116,636.2
Гамшиг судлалын хүрээлэн	1	135,234.2	-	-	-	-	1	135,234.2
Үндэсний аврах бригад	1	38,372.5	-	-	-	-	1	38,372.5
Сонгинохайрхан дүүргийн ОБХ	1	245,205.8	-	-	-	-	1	245,205.8
Сүхбаатар дүүргийн ОБХ	1	1,105,010.6	-	-	-	-	1	1,105,010.6
Баянзүрх дүүргийн ОБХ	1	335,352.7	-	-	1	335,352.7	-	-
Архангай аймгийн ОБГ	1	-	-	-	1	-	-	-
Баян-Өлгий аймгийн ОБГ	1	35,510.0	-	-	-	-	1	35,510.0
Говьсүмбэр аймгийн ОБГ	1	95,410.4	-	-	-	-	1	95,410.4
Дархан-Уул аймгийн ОБГ	1	118,356.8	-	-	-	-	1	118,356.8
Дундговь аймгийн ОБГ	1	-	-	-	-	-	1	-
Өмнөговь аймгийн ОБГ	1	1,461,234.3	-	-	1	1,461,234.3	-	-
Дүн	**23**	**54,069,212.7**	**-**	**-**	**3**	**1,796,587.0**	**20**	**52,272,625.7**
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Онцгой байдлын ерөнхий газрын ТТЗ	1	4,167,233.5	-	-	1	4,167,233.5	-	-
Онцгой байдлын ерөнхий газар ТШЗ	2	21,586,326.8	-	-	1	1,275,820.9	1	20,310,505.9
Агааараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги	1	49,389.5	-	-	1	49,389.5	-	-
112 дугаар анги	1	130,000.0	-	-	1	130,000.0	-	-
Ар талын 115 дугаар анги	3	1,062,450.0	-	-	1	300,000.0	2	762,450.0
Аврагч биеийн тамир, техник-спорт хороо 120 дугаар анги	1	-	-	-	-	-	1	

Онцгой тусгай хувцас, хэрэгслийн туршилт үйлдвэрлэлийн төв 121 дүгээр анги	1	935,134.3	-	-	1	935,134.3	-	-
Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, туршилт үйлдвэрийн төв 123 дугаар анги	1	80,000.0	-	-	1	80,000.0	-	-
185 дугаар анги	1	785,000.0	-	-	1	785,000.0	-	-
Гамшиг судлалын хүрээлэн	2	69,740.0	-	-	1	69,740.0	1	-
Нийслэлийн ОБГ	2	153,239.9	-	-	-	-	2	153,239.9
Сонгинохайрхан дүүргийн ОБХ	2	211,867.2	-	-	-	-	2	211,867.2
Сүхбаатар дүүргийн ОБХ	2	142,259.9	-	-	1	142,259.9	1	-
Хан-Уул дүүргийн ОБХ	2	254,550.5	-	-	1	254,550.5	1	-
Чингэлтэй дүүргийн ОБХ	2	94,574.2	-	-	-	-	2	94,574.2
Багахангай дүүргийн ОБХ	1	-	-	-	-	-	1	-
Налайх дүүргийн ОБХ	3	98,824.4	-	-	1	50,000.0	2	48,824.4
Багануур дүүргийн ОБХ	2	73,126.2	-	-	1	73,126.2	1	-
Баянгол дүүргийн ОБХ	2	118,914.3	-	-	-	-	2	118,914.3
Баянзүрх дүүргийн ОБХ	2	115,957.2	-	-	-	-	2	115,957.2
Говь-Алтай аймгийн ОБГ	2	21,641.1	-	-	2	21,641.1	-	-
Дархан-Уул аймгийн ОБГ	1	130,740.0	-	-	1	130,740.0	-	-
Дундговь аймгийн ОБГ	1	22,668.6	-	-	1	22,668.6	-	-
Сэлэнгэ аймгийн ОБГ	1	99,090.4	-	-	1	99,090.4	-	-
Ховд аймгийн ОБГ	1	170,014.3	-	-	-	-	1	170,014.3
Дүн	**40**	**30,572,742.3**	**-**	**-**	**18**	**8,586,394.9**	**22**	**21,986,347.4**
Нийт дүн	**63**	**84,641,955.0**	**-**	**-**	**21**	**10,382,981.9**	**42**	**74,258,973.1**